



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/ЮЧ


Бөхт

Хүүхдийн цэцэрлэгийн бүтэц орон тоог
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. Манлайлах ур чадвараа дээшлүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хариуцлагатай, идэвх санаачилгатай хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны
өдрийн А/04 дүгээр захирамжийн хавсралт

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН АЛБАН ХААГЧДЫН БҮТЭЦ ОРОН ТОО

Д/д	Ажлын байрны нэр	Ажил эрхлэгчийн тоо	Хариуцах чиг үүрэг
1	Эрхлэгч	1	Хүүхдийн цэцэрлэгийн хөгжлийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтийг манлайлах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх үндсэн дээр цэцэрлэгийн үйл ажиллагааг захиргааны удирдлагаар ханган, багш хүүхдүүдэд цогц чадамжид сурилсан СӨБ-ын стандартыг хэрэгжүүлэхэд нь үйлчилгээ үзүүлэх
2	Аргазүйч	1	Цогц чадамжид суурилсан СӨБ-ын стандартыг хангах түвшинд суралцагчдад боловсрол эзэмшүүлж, тэднийг сургах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдан чиглүүлэх
3	Бүлгийн багш	4	Цогц чадамжид суурилсан СӨБ-ын стандартыг хангах түвшинд суралцагчдад боловсрол эзэмшүүлж, тэднийг сургах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдан чиглүүлэх
4	Туслах багш	4	Бүлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн норм, нормативыг хангах, хүүхэд бүрийг халамжлах, эрүүл мэндийн зөв дадал хэвшилтэй болоход хүүхдэд туслах, хүүхдийн эцэг эхэд туслалцаа үзүүлэх, хичээл үйл ажиллагааг зохион байгуулахад багшид туслах
5	Нярав	1	Цэцэрлэгийн аж ахуйн үйл ажиллагааг хариуцан үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хангамж, зарцуулалт, хөдөлгөөнийг гардан гүйцэтгэх, складын бүртгэл, тайлан тооцоог гүйцэтгэх.
6	Тогооч	2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн норм, эрүүл ахуйн стандартыг хариуцан хүнсний бараа материалын хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих, эрүүл илчлэг сайтай, амт чанар сайтай, олон нэр төрлийн чанартай хүртээмжтэй хүнсээр бага насны хүүхдийг хангах гүйцэтгэх.
7	Үйлчлэгч	1	Цэцэрлэгийн байрны ариун цэвэр, эрүүл ахуйн стандартын норм, нормативыг хангаж цэвэр орчин бүрдүүлэн ажиллах.
8	Жижүүр	2	Цэцэрлэгийн барилга болон эд зүйлсийн хадгалалт хамгаалалтын бүрэн бүтэн байдалд хяналт тавих, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах
9	Эмч	0,5	Ажилчид, хүүхдийг эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт хамруулах, хүүхдийн хоол цайны дээж авалт, устгалтыг хийх, тэмдэглэх, хяналт тавих, цэцэрлэгийн ариун цэвэр, эрүүл ахуйн норм, нормативыг хангахад хяналт тавих, хариуцан ажиллах
10	Нягтлан бодогч	0,5	Байгууллагын төсвийн орлого зарлага зарцуулалтын мэдээг тухай бүрт гарган тайлагнаж байгууллагын төсвийн зарцуулалтад байгууллагын удирдлагатай хамтран ажиллах